



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 463

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 344 дүгээр тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт болон Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 14.2, 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 344 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 11 дэх заалтуудыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт:**

“2.1.4. энэ журмын хавсралтын дагуу батлан даалтын мэдээ, зээлийн эргэн төлөлтийн сар бүрийн тайланг дараа сарын 10-ны, улирлын санхүүгийн тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор тус тус Хороонд ирүүлэх”.

**2/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:**

“2.1.11. Сан нь батлан даалтын үүрэг гүйцэтгэх чадварыг хангах үүднээс эрсдэлийн сантай байна”.

2. Мөн журмын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурьдсан агуулга бүхий 2.1.12 дахь заалтыг нэмсүгэй:

**1/ 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:**

“2.1.12. Эрсдэлийн санг тайлант хугацааны эцэс дэх цэвэр орлогоос түүний 50-иас доошгүй хувиар байгуулна. Эрсдэлийн сангийн хөрөнгийг банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах бөгөөд үйл ажиллагаанд зарцуулахыг хориглоно.”.

3. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

930799